


ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГТЭЙ ТАНИЛЦСАН  
421 ДҮГЭЭР НЭЭЛТТЭЙ ХОРИХ АНГИЙН  
ДАРГА, ХУРАНДАА *Г.Тамир* Г.ТАМИР

2020 ОНЫ 02 ДУГААР САРЫН 20



421 ДҮГЭЭР ЭЭЛТТЭЙ ХОРИХ АНГИД БАРИЛГЫН  
МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: БАРИЛГЫН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ  
Төслийн дугаар: ШШГЕГХ421А/202002001

УЛААНБААТАР ХОТ 2020 ОН

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

421 дүгээр нээлттэй хорих анги нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “ШШГЕГ-ын 421 дүгээр нээлттэй хорих ангид Барилгын материал нийлүүлэх” тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн материалыг цахим худалдан авах ажиллагааны систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэрээр (pdf)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50.000 /тавин мянга/ төгрөгийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) –ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.

Үнийн саналыг 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 10-р хороо, Амгалан 421 дүгээр нээлттэй хорих анги-д 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 10-р хороо, Амгалан 421 дүгээр нээлттэй хорих анги,  
утас: 91057709, 80672828, 89982808

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа	1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт	2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. 2.2 Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл	3.1 Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд: (а) Үнийн санал; (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь; (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан-2019, (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
4. Тогтмол үнэ	4.1 Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд	5.1 Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа	6.1 Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 5 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх	7.1 Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. 7.1. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл	8.1 Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа /ТӨӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүйл
ТӨӨЗ 1.1	Сүүлийн 1 жил буюу 2019 оны санхүүгийн тайлан ирүүлэх,
ТӨӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугааа нь: Бйгууллагын хаяг: БЗД 10-р хороо, Амгалан ШШГЕГ-ын харъяа 421 дүгээр нээлттэй хорих анги 2 дугаар давхар санхүүгийн өрөө, аж ахуйн ажилтны өрөө дэслэгч, Ц.Сэргэлэн Огноо: 2020 оны 03 дугаар сарын 03 өдөр Цаг: 10 цаг 00 минутаас өмнө
ТӨӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: БЗД-10-р хороо, Амгалан ШШГЕГ-ын харъяа 421 дүгээр нээлттэй хорих анги, хурлын танхим Огноо: 2020 оны 03 дугаар сарын 03 өдөр Цаг 10 цаг 30 минут
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцаас бүрдэнэ. Үүнд: Багц -1 Сантехник, цэвэр бохир усны шугамын материал-38.100.000 төгрөг Багц-2 Бусад-10.899.000 төгрөг

1. Бараа хүргэх газар: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 10-р хороо, Амгалан 421-р нээлттэй хорих ангийн байр
2. Бараа нийлүүлэх хуваарь

**Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**Багц-1 Сантехник, цэвэр бохир усны шугамын материал /импортын/**

Д/д	Материал нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	Ф40 Труба	М	250
2	Ф25 Труба	М	100
3	Ф20 Труба	М	100
4	Ф40 хаалт гагнадаг	М	6
5	Ф32 хаалт /гагнадаг/	Ш	6
6	Ф20 хаалт	Ш	120
7	40*20 тройник	Ш	82
8	40-25 тройник	Ш	60
9	25*20 тройник	Ш	60
10	Ф20 тройник	Ш	60
11	Олс /сангийн/	Ш	100

12	Лент /сангийн/	Ш	100
13	40 изгон	Ш	40
14	Ф32 изгон	Ш	20
15	25 Изгон	Ш	80
16	20 Изгон	Ш	180
17	Ф40 булан	Ш	40
18	Ф20 булан	Ш	60
19	Паар /хятад/	Ш	300
20	Плита 60*60 /саарал/	Ш	450
21	Плита 60*30 /Цайвар бор/	Ш	900
22	Цавуу 10 кг /хулдаасны/	Ш	10
23	107 цавуу /100гр/	Ш	50
24	Угаалтуур /хөлтэй 3-н нүхтэй/	Ш	12
25	Суултуур /үргэлж/	Ш	7
26	Босоо шээлтүүр /дундынх/	Ш	10
27	Бойлуур /80л/	Ш	5
28	Холигч /халуун хүйтэн усны/	Ш	12
29	Шпател /хуванцар/	Ш	20
30	Шпател /төмөр/	Ш	10
31	Эмульс /18кг/ цагаан	сав	30
32	Будаг /18 кг/ цагаан	сав	30
33	Багс /том/	Ш	5
34	багс /дунд/	ш	5
35	Багс /жижиг/	ш	10
36	Өнхрүүш /том/	Ш	11
37	Өнхрүүш /жижиг/	ш	20
38	Сифон /орос цагаан/	Ш	12
39	Чигжээс /2 кгтай/	Ш	20
40	Солонгос хулдаас /дүйцэхүйц/	М	420
41	Гармуушка	Ш	7
42	Уян холбоос /60см/	Ш	35
43	Вакум насос /125w/	Ш	2
44	370w винтлятор	Ш	2
45	Электрод /3/	Ш	20
46	Электрод /2/	ш	20
47	Таслагч ир 100-тай	Ш	1000
48	Силикон /солонгос/ дүйцэхүйц	Ш	40
49	Шахдаг хөөс /солонгос/ дүйцэхүйц	Ш	20
50	Шруп /3/	Хайрцаг	20
51	Шруп /5/	Хайрцаг	10
52	Шруп /7/	Хайрцаг	10
53	Шруп /10/	Хайрцаг	10
54	Замаска /25 кг/	Уут	80
55	Арматур	Тн	1.5

## Багц-2 бусад материал

1	Цемент	ТН	30
2	Элс /Бохир/	М³	100
3	Хайрга /0.5 тай/	М³	100
4	Хайрга /10.20-тай/	М³	100
5	Цемент /Монгол/	ТН	30
6	Элс /Бохир/	М³	100
7	Хайрга /0.5 тай/	М³	100
8	Хайрга /10.20-тай/	М³	100
9	Гэрэл лед /том/	ш	20
10	Гэрэл лед /жижиг/	ш	23
11	Далдлагч	ш	38
12	Нүдний шил	ш	1

### ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Нийлүүлэгдэж байгаа өндөр даралтын труба нь дотор талдаа ямар нэг эрчлээдэсгүй, тэнхлэгийн дагуу ханын зузаан нь жигд, стандартын шаардлагын хангасан чанартай труба байх шаардлагатай.
2. Сэлбэг, материал нь ОХУ-ын ГОСТ стандартын шаардлага хангасан байна.
3. Горим ажиллагаа, техникийн үзүүлэлттэй нийцсэн байх бөгөөд олон улсын стандарт шаардлага хангасан, тоо ширхэг бүрэн, урд нь ашиглагдаагүй, шинэ байна.
4. Сэлбэг, материал нь үйлдвэрлэгчийн дагалдах сертификат, чанарын гэрчилгээ, гарал үүслийг нотлох баримт, хаяг шошготой байна.
5. Хаалт арматур бүрэн тосолгоо хийгдсэн байна.
6. 0.2-1,6 МПа даралт тэсвэрлэхээр байна.

### БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

ТӨШХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийннөхцлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
	Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
421 дүгээр нээлттэй хорих анги	2020.03.01	2020.12.31	

Гурав. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |       |  |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна.  |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор шуурхай хийнэ.   |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |



## Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |  |  |
|--|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1)                             | 1.1 421 дүгээр нээлттэй хорих ангиас томилогдсон комисс мэргэжлийн хяналтын байгууллагын шинжилгээний дүгнэлтийг үндэслэн шалгаж хүлээн авна.  |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1 ийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: <ul style="list-style-type: none"><li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li><li>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;</li><li>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li><li>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</li><li>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li></ul> <p style="margin-left: 40px;">Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5)                                  | 3.1 Баталгаат засварын тусгай шаардлага.<br>Нийлүүлсэн бүтээгдэхүүнийг хэрэглэх явцад гарсан гологдлыг тухай бүр шинэчлэн сольж өгнө.  |
| 4. Төлбөр (ГЕН – 7)  | 7.1 Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br>Захиалагч Монгол Улсын гаднаас санал болгосон барааны төлбөрийг нийлүүлэгчид дараах журмын дагуухийнэ. <ul style="list-style-type: none"><li>1. Урьдчилгаа төлбөр: Байхгүй</li><li>2. Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр: Байхгүй.</li><li>3. Барааг хүлээн авахад төлөх төлбөр: 100 хувь /<br/>Барааны төлбөрийг гүйцэтгэлээр нь буюу бараа хүлээн авсанаас хойш 10 хоногийн дотор нэхэмжлэх болон захиалагчийг хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.</li></ul>  |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9) <sup>1</sup>                 | 4.1 Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн 7 хоног тутамд 0,5%<br><br>Алдангийн нийт дүн: 10% иас хэтрэхгүй байна.  |

---

1. Ихэнхи иохиолдолд нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Найм. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>2</sup>

БАТЛАВ:

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/ гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

2. Гэрээ байгуулах үед үүнийг хасна.  
3. Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]